



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/185


Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "г", 30.1.6 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны ээлжит IX хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын хяналтын камерийн кабелийн худаг, суваг, сувагчлал, агаарын баганы түрээсийн төлбөрийн 2019 оны 2, 3, 4 дүгээр улирлын 2,534,103 (Хоёр сая таван зуун гучин дөрвөн мянга нэг зуун гурван) төгрөгийг "Мэдээдэл холбоо сүлжээ" Төрийн өмчит ХХК-ний Хөвсгөл аймгийн газарт олгосугай.


2. Дээрх зардлын 2,534,103 (Хоёр сая таван зуун гучин дөрвөн мянга нэг зуун гурван) төгрөгийг аймгийн Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн ерөнхий нягтлан бодогч (Ц.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Л.ГАНБОЛД

Боловсруулсан:

Хянасан:

2 хувь

 Х.Цэнд-Аюуш
Г.Гандэлгэр



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/186

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хөгжимт драмын театрын барилга ашиглалтын шаардлага хангахгүй нөхцөл байдал үүссэн тул эрсдлийн үнэлгээ хийж засварлах боломжтой эсэхийг тогтоох, зураг төсөв бэлтгэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ганболд-Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүдэд:

Д.Мягмарсүрэн –Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн
хяналтын улсын байцаагч

Н.Шинэбаяр – Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
мэргэжилтэн

А.Баянхангай – Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн улсын
хяналтын байцаагч



Нарийн бичгийн дарга:Л.Батцэцэг-Аймгийн Хөгжимт драмын театрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч

2. Барилгад үүссэн нөхцөл байдлыг судалж, эрсдлийн үнэлээ хийж, барилгыг засварлах ашиглах боломжтой эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ж.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь

Г.Нарангэрэл
Ж.Ганболд



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/187

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5.-ын "а", Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3 дахь заалт Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.4 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн төрийн албан хаагчдын спортын тэмцээний зардлын үлдэгдэл 1,890,000 мянган төгрөг, төрийн албан хаагчдын англи хэлний олимпиадын зардлын 1,438,000 мянган төгрөгийн задаргааг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх 3,328,000 (Гурван сая гурван зуун хорин найман мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Ө.Баттулга
Х.Цэнд-Аюуш

Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 09 -ны өдрийн А/187
дугаар захирамжийн хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СПОРТЫН
ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ҮЛДЭГДЭЛ

№	Зардал	Мөнгөн дүн
1	Сагсан бөмбөгийн тэмцээний шүүгчдийн хөлс	1,140,000
2	Воллейболын тэмцээний шүүгчдийн хөлс	540, 000
3	Анонс.	210,000
	Нийт	1,890,000

ИРГЭД, ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АНГЛИ ХЭЛНИЙ
ОЛИМПИАДЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Утга	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Шагнал	1-р байр	ш	3	100,000	300,000
		2-р байр	ш	3	80,000	240,000
		3-р байр	ш	3	50,000	150,000
		Шалгарсан сум, агентлаг	ш	2	100,000	200,000
		Медаль	ш	9	7,000	63,000
		Өргөмжлөлийн хуулга	ш	11		20,000
		Баннер	м/кв	18	10,000	180,000
		Нийт				
4.	Шалгалтын зардал	Бичгийн цаас	боодол	1	10,000	10,000
		Онлайн олимпиад	хүн	6	12,500	75,000
		Бичгийн шалгалт, дүн	Хүн	10	12,500	125,000
		Ярианы шалгалт	Хүн	6	12,500	75,000
		Нийт				
					1,438,000	





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/189

Мөрөн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18, заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл сунгах аж ахуйн нэгж байгууллагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (А.Эрдэнэбаатар), Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр) нарт үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн багц хууль, эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудад холбогдох стандартууд, эмнэл зүйн удирдамжуудыг мөрдөж ажиллахыг эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд даалгасугай.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Ж.Ганболд)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Zahiramj-2019-A

01110502

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Д.Батцоож
Ж.Ганболд

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар
сарын 09 -ны өдрийн А/189 дугаар
захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Эрхлэх үйл ажиллагааны чиглэл	Ажлын байрны хаяг	Тусгай зөвшөөрөл сунгасан хугацаа
1	Тариалан сумын ЭМТ	Д.Дуламсүрэн	Анхан шатны тусламж үйлчилгээ	Тариалан сумын төвд	2019-04-28 2024-04-28
2	Цэцэрлэг сумын ЭМТ	Х.Энхсүрэн	Анхан шатны тусламж үйлчилгээ	Цэцэрлэг сумын төвд	2019-04-28 2024-04-28
3	Арбулаг ЭМТ дарга	Г.Бямбадорж	Анхан шатны тусламж үйлчилгээ	Цэцэрлэг сумын төвд	2019-04-28 2024-04-28
4	Тосонцэнгэл ЭМТ	Г.Дэлгэрмаа	Анхан шатны тусламж үйлчилгээ	Цэцэрлэг сумын төвд	2019-04-28 2024-04-28
5	Их-Уул сумын СДЭ	Д.Болд-Эрдэнэ	Анхан шатны тусламж үйлчилгээ	Цэцэрлэг сумын төвд	2019-04-28 2024-04-28
6	Шинэ-Идэр СДЭ-ийн	Б.Мөнх-Эрдэнэ	Анхан шатны тусламж үйлчилгээ	Цэцэрлэг сумын төвд	2019-04-28 2024-04-28
7	“Энх-Үрс” ХХК-ийн Энх-Үрс эмнэлэг	П.Аюушжав	Хүүхдийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	Мөрөн сум 8-р баг, Нэгдсэн эмнэлгийн хашаанд	2019-04-28 2024-04-28
8	“Хөвсгөл ренчинжугнай” ХХК-ийн Ренчинжугнай эмнэлэг.	П.Эрдэнэчулуун	Дотор мэдрэлийн амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ	Мөрөн сум 8-р баг, Нэгдсэн эмнэлгийн хашаанд	2019-04-28 2024-04-28
9	“Бажгар Оюу” ХХК-ийн “Асгат оюу” мэдрэлийн клиник.	Д.Оюунчулуун	Мэдрэлийн клиник.	Мөрөн сум 8-р баг, Жаргалан эмнэлгийн хашаанд	2019-04-28 2024-04-28
10	“Цахир-Оюу” ХХК-ийн “Цахир” дотрын клиник.	З.Оюунчимэг	Дотрын клиник.	Мөрөн сум 8-р баг, Жаргалан эмнэлгийн хашаанд	2019-04-28 2024-04-28

11	“Дэлхийн хөх алмааз” ХХК-ийн Энхбаян эмэгтэйчүүдийн клиник	Ц.Баянжаргал	Эмэгтэйчүүдийн клиник	Мөрөн сум 8-р баг, Жаргалан эмнэлгийн хашаанд	2019-04-28 2024-04-28
12	“Мөнхтэнцвэр” ХХК-ийн “Мөнхтэнцвэр” лаборатори.	Д.Пүрэвжав	Клиникхими, клиникгематлог и, биохими, иммунологи, Серилоги	Мөрөн сум 8-р баг, Оюу-Ундраа эмнэлгийн хашаанд	2019-04-11 2024-04-11
13	“Хөвсгөл эм хангамж” ХХК-ийн эмийн сан.	П.Номин	1 дүгээр зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 8-р баг, “Хөвсгөл эм хангамж” ХХК-ийн байранд	2019-04-28 2024-04-28
14	“Хөвсгөл эм хангамж” ХХК-ийн ЭХНБ.	Э.Ичинноров	Эмханган нийлүүлэх байгууллага	Мөрөн сум 8-р баг, “Хөвсгөл эм хангамж” ХХК-ийн байранд	2019-04-28 2024-04-28
15	Хачим-Уул” ХХК-ийн Хүрэн уул эмийн сан	Х.Бүрэнжаргал	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Ренчинлхүм бэ сумын төвд	2019-02-22 2024-02-22
16	“Элбэрэлт тун” ХХК-ийн Далай ээж эмийн сан.	Ж.Бямбаа	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Хатгал тосгоны төвд	2019-04-28 2024-04-28
17	“Инжир гурван үндэс” ХХК-ийн “Инжир” эмийн сан.	Л.Нямдаваа	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Их-Уул сумын төвд төвд	2019-04-28 2024-04-28
18	“Марал Од-гариг” ХХК-ийн Марал эмийн сан.	Б.Түвшинзаяа	1 дүгээр зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 8-р баг, 16-3-27	2019-04-28 2024-04-28
19	“Нар баясах” ХХК-ийн ган эмийн сан.	М.Баасанноров	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 8-р баг, 14-3	2019-04-28 2024-04-28
20	“Хөвсгөл Ивээл” ХХК-ийн Ивээл эмийн сан.	Ж.Нарангэрэл	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Мөрөн сум 5-р баг, Далай-Ээж захын хашаанд	2019-04-28 2024-04-28
21	“Идэр фарм” ХХК-ийн “Идэр” эмийн сан.	Г.Ариунаа	2 дугаар зэрэглэлийн эмийн сан	Шинэ-Идэр сумын төвд төвд	2019-04-28 2024-04-28





МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар A/190

Мөрөн сум

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн "а", 29.2, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3.2, 30.3.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч болон Хөвсгөл аймгийн Засаг даргын хооронд хөтөлбөрийн хэрэгжүүлэлт, санхүүжилтийн талаар 2019 онд байгуулсан гэрээг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймагт зохион байгуулагдах хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тоон болон чанарын судалгааг хийх ажлын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, судалгааны багийн ажлын чиглэлийг хоёрдугаар, шаардагдах төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үр дүнгийн тоон болон чанарын судалгааг 2019 оны 5 дугаар сарын 10 -наас 2019 оны 7 дугаар сарын 15-ны дотор авч явц, үр дүнг 8 дугаар сард багтаан Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг ажлын багийн ахлагч (Ц.Баттогтох)-д даалгасугай.

3. Судалгаанд аймгаас зарцуулагдах 10,000,000 (Арван сая) төгрөгийг "Ажилтай орлоготой Хөвсгөл" хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Сувд)-д зөвшөөрсүгэй.

4. Судалгааг зохион байгуулахад шаардагдах бусад зардлыг холбогдох байгууллага, төсөл, хөтөлбөрт уламжилж шийдвэрлүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ц.Баттогтох)-д даалгасугай

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Д.Батцуж
Ж.Ганболд

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 09 өдрийн А/190 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ,
НИЙЛҮҮЛЭЛТ, ҮР ДҮНГИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН
СУДАЛГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч : Ц.Баттогтох-Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: Ж.Ганболд- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Э.Аззаяа-Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн дарга

Б.Базардамбуу -Статистикийн хэлтсийн дарга

Г.Баттулга –Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Ганзориг-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга

Ч.Дашбаяр-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

М.Үүрийнбаяр-Эрүүл мэндийн газрын дарга

Л.Юмжирдулам-Нийгмийн даатгалын хэлтсийн дарга

Ж.Жаргалсайхан-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Ч.Хуншагай-Татварын хэлтсийн дарга

Б.Эрдэнэбилэг-Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Ц.Гансүх-Мөрөн сумын Засаг дарга

Д.Цэцэгмаа - Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Ш.Отгон-Эрдэнэ-Боловсрол, соёл урлагийн газрын Дэд дарга

Н.Баатар-Очир- Хөвсгөл Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн
захирал

Д.Цогтоо-“Далай ван” сургуулийн захирал

Ж.Сарангэрэл-Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Ц.Ганболд- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

Нарийн бичгийн дарга: Б.Мөнхжаргал-Аймгийн Хөдөлмөр, халамж
үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Ж.Ганболд -Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Л.Занданмядагсүрэн- Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн

Бодлого, төвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
С.Эрдэнэтуяа- Татварын хэлтсийн улсын байцаагч
Отгонбаяр-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Г.Цогбаяр-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Төсөл хөтөлбөр
хариуцсан мэргэжилтэн
З.Отгонбаяр-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн
мэргэжилтэн
Ш.Пүрэвдалай -Хөвсгөл Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн НТА-ны
менежер
Д.Насанбуян-Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээдийн улсын бүртгэгч
П.Хуншагай- Боловсрол соёл урлагийн газрын Статистикийн мэргэжилтэн
Б.Өлзийсүрэн- Эрүүл мэндийн газрын Статистикийн мэргэжилтэн
У.Цэцэгдэмбэрэл-“Далай ван” сургуулийн дэд захирал
Я.Түвшинжаргал-Нийгмийн даатгалын хэлтсийн Тамгын дарга

СУДАЛГАА АВАХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:Б -Б.Эрдэнэтуяа-Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
дарга
Гишүүд: Б.Болорчимэг-Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн Хүний
нөөцийн ажилтан
Н.Алтансүх- Ажил олгогч эздийн холбооны төлөөлөл
Г.Давгадорж-Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл
Б.Эрдэнэбат- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжилтэн
Л.Алтансүх- Аймгийн Ажил олгогч эздийн холбооны ажилтан
Т.Энхтунгалаг-Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл
Х.Чимэдцэеэ -Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл

МӨРӨН СУМАНД СУДАЛГАА АВАХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Г.Нэргүй-Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүд: Б.Ширжанцан- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн
мэргэжилтэн
Ч.Энхбаяр- Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн
С.Сармандах-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Р.Отгонцэцэг-Статистикийн хэлтсийн мэргэжилтэн
Т.Сандагдорж-Аймгийн Ажил олгогч эздийн холбооны ажилтан
Т.Дэлгэр- Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл

СУДАЛГААНЫ БОЛОВСРУУЛАЛТ ХИЙХ ДЭД БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Н.Баатар-Очир- Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн
захирал
Гишүүд:
Б.Янжиндолгор-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн
Т.Алтанцэцэг-Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
Б.Лхагваа-“Хөвсгөл хөгжил дэвшил” ТББ-ын тэргүүн
Г.Базар-Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Б.Лхамсүрэн-“Өөжин буурал” ТББ менежер

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН
ЭРЭЛТИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГАА ХИЙХ
БАГУУДЫН АЖЛЫН ЧИГЛЭЛ**

1. Удирдлагын баг - Ц.БАТТОГТОХ

- Төсөв санхүүг зохицуулах
- Судалгааны зорилгыг тодорхойлох
- Хамрах хүрээг тогтоох
- Явах маршрут гаргах
- Төлөвлөгөө гаргах
- Холбогдох байгууллагуудад албан тоот, зөвлөмж, даалгавар хүргүүлэх ажлыг зохион байгуулах
 - Тайлантай танилцаж дүгнэлт өгөх
 - Явцын хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх
 - Судалгааны дүнг түгээн дэлгэрүүлэх ажлыг төлөвлөгөө гарган зохион байгуулах
 - Үр дүнг жил бүр хянах, санал дүгнэлт гаргах
 - Судалгааны өмнөх сургалтуудыг зохион байгуулах ажил олгогч нарт зориулсан бизнесийн болон хүний нөөцийн сургалт, ХХҮГ-аас судлаач нарт зааварчилгаа өгөх, гарын авлага боловсруулах, МСҮТ-өөс зааварчилгаа авах, мэргэжлийн судлаачаас зааварчилгаа авах,

Мэдээлэл цуглуулах баг- Ж.ГАНБОЛД

Ажлын төлөвлөгөө гаргаж Удирдлагын багаар хянан батлуулах

- Албан болон албан бус статистик мэдээ гаргах
- Аймаг орон нутгийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдээс холбогдох мэдээллийг цуглуулах
 - Төсвийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн болон донор байгууллагуудын хүрээний хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой мэдээлэл, тайлангуудаас шаардлагатай мэдээллүүдийг авах
 - Шинээр хийгдэх бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажиллах хүчний эрэлтийг тодорхойлох /мэргэжил, ур чадвар, хандлага/
 - Төрийн бус байгууллагуудын судалгаа, тайлангууд
 - Мэдээлэлд анхан шатны боловсруулалт хийж, урьдчилсан тайланг гаргах
 - Нийлүүлэлтийн мэдээллийг цуглуулах /их, дээд сургууль, МСҮТ, коллежид суралцагчдын мэдээлэл/

2. Судалгааны баг- Б.ЭРДЭНЭХУЯГ

- Ажлын төлөвлөгөө гаргаж Удирдлагын багаар батлуулах
- Судлаач, багийн ахлагчийг сонгох, чадавхжуулах, арга зүй зөвлөгөө, сургалтанд хамрагдах
 - Судлаачдын үүрэг чиглэл, ёс зүй, хариуцлагыг тодорхойлох
 - Судлаачидтай гэрээ байгуулах
 - Судлаачдын ажлын талбарыг тодорхойлох, зураглал гаргах

- Судлаачдын судалгааны явцад хяналт тавих
- Асуулгын хуудсыг шивсэн файлтай тулгаж хянаж хүлээн авах, боловсруулалтын багт хүлээлгэж өгөх

3. Боловсруулалтын баг- Н.БААТАР-ОЧИР

- Ажлын төлөвлөгөө гаргаж Удирдлагын багаар хянуулж, батлуулах
- Судалгааны арга зүй, аргачлалыг боловсруулах
- Судалгааны асуулга боловсруулах /зорилтот бүлэг бүрээр/
- Судалгааны түүвэр тодорхойлох
- Асуулгын хуудсыг шивсэн файлтай тулгаж хянаж хүлээн авах,
- Зөвлөхүүдтэй хамтарч ажиллах
- Мэдээллийн болон судалгааны үр дүнг нэгтгэн боловсруулах, тайлан бичих
- Дүгнэлт, зөвлөмж гаргах
- Холбогдох байгууллагуудад тайлан, дүгнэлт, үр дүнг танилцуулах
- Судалгааны тайланг холбогдох байгууллага, удирдлагын багт хүлээлгэн өгөх

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 09... өдрийн А/190 дугаар
захиралжийн 3 дугаар хавсралт

**ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТИЙН ТООН БОЛОН ЧАНАРЫН СУДАЛГАА ХИЙХ
ЗАРДЛЫН ТООЦОО**

Зардлын нэр төрөл							Дүн		Хаанаас санхүүжүүлэх
Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Нийт хоног	Тоо ширхэг	Нэгжийн зардал	Нийт зардал				
1 Бичгийн цаас	боодол		10	10500	105 000,00				
2 Асуулга хэвлүүлэх зардал	хувь		12000	800	9 600 000,00				
3 Тайлан хэвлүүлэх зардал	хувь		100	30000	3 000 000,00				
4 Мэдээлэл боловсруулалт, тайлан бэлтгэх зардал	хүн/өдөр		200	7000	1 400 000,00				
1. Бичиг хэргийн зардлын дүн							14 105 000,00		
Хэрэглэгдэхүүн	Хэмжих нэгж	Нийт хоног	Оролцогчдын тоо	Нэг өдрийн зардал	Нийт зардал				
1 Цайны завсарлага /өглөө/		1	34	3500	119 000,00				
2 Үдийн хоол		1	34	15000	510 000,00				
3 Цайны завсарлага /орой/		1	34	3500	119 000,00				
2. Судалгаа авах ажилтнуудын сургалтын үдийн хоол, цайны завсарлагын зардлын дүн							748 000,00		
Унааны зардал	Хэмжих нэгж	Замын урт	Зарцуулах шатахуун	Шатахууны үнэ	Нийт зардал				
1 Бензин /1-р бүс/	л	780	195	2350	458 250,00				
2 Бензин /2-р бүс/	л	800	200	2350	470 000,00				
3 Бензин /3-р бүс/	л	750	187,5	2350	440 625,00				

4	Бензин /4-р бүс/	л	650	162,5	2350	381 875,00
5	Бензин /5-р бүс/	л	350	87,5	2350	205 625,00
3. Унааны зардлын дүн						
832,5						
Томилолтын зардал						
1	1-р бүс	Хэмжих нэгж хоног	Нийт хоног	Хүний тоо	Өдрийн хөлс	Нийт зардал
			8	5	12000	480 000,00
2	2-р бүс		9	5	12000	540 000,00
3	3-р бүс		8	5	12000	480 000,00
4	4-р бүс					-
5	5-р бүс					
4. Жолоочийн хөлс						
1 500 000,00						
Зочид буудлын зардал						
		Зорилгот бүлэг	Байрлах хүний тоо	Буудалд байрлах хоног	Нэг хүний ор	Нийт зардал
1	1-р бүс		5	7	14500	507 500,00
2	2-р бүс		5	8	14500	580 000,00
3	3-р бүс		5	7	14500	507 500,00
5. Зочид буудлын зардлын дүн						
1 595 000,00						
Урамшууллын зардал						
			Хүний тоо	Нийт хоног	Нэг өдрийн урамшуулал	Нийт зардал
1	1-р бүс		5	7	40000	1 400 000,00
2	2-р бүс		5	8	40000	1 600 000,00
3	3-р бүс		5	7	40000	1 400 000,00
4	4-р бүс		7	10	40000	2 800 000,00

5	Мэдээлэл нэгтгэгч баг		6	14	40000	3 360 000,00
6	Боловсруулалт хийх баг		6	14	50000	4 200 000,00
6. Урамшууллын зардлын дүн						
Сургалтын нийт зардал						
14 760 000,00						
34 664 375,00						
31 113 000,00						
Үүнээс ШХА-ийн ББМБС-ын төслөөс санхүүжүүлэх зардлын дүн						

_____оОо_____



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/191

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61.1.10, Засгийн газрын 2019 оны 150 дугаар тогтоол, Ерөнхий сайдын 2019 оны 46 дугаар захирамж, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг угтан аймгийн төрийн болон төрийн өмчийн аж ахуйн нэгж, сумдын Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн ажилтнуудыг мэргэжил арга зүй, мэдээллээр хангах сургалтад шаардагдах 1.071.500 (Нэг сая далан нэгэн мянга таван зуун) төгрөгийг гаргаж зарцуулсугай

2. Дээрх 1,071,500 (Нэг сая далан нэгэн мянга таван зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь

A handwritten signature in black ink, consisting of several fluid, overlapping strokes.

Д.Нам-Эрдэнэ
Ж.Жаргалсайхан



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/192

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалын 2.1.5 дахь заалтыг тус тус, үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Улсын Онцгой комисс Хөвсгөл аймагт ажилласантай холбогдуулан гарсан зардлын 319,100 (Гурван зуун арван есөн мянга нэг зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 319,100 (Гурван зуун арван есөн мянга нэг зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь

 Х.Цэнд-Аюуш
Гандэлгэр



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А1193

Мөрөн сум

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а", Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.4-т заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, мэдлэг олгох, зөв дадалд хэвшүүлэх зорилготой "Эрүүл ахуйн 3 дадал" аяны удирдамжийг нэгдүгээр, зохион байгуулах ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Салбар дундын хамтын ажиллагааг хангаж аяныг зохион байгуулах ажлыг удирдлага, зохион байгууллалтаар хангаж үр дүнтэй ажиллахыг аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга, ажлын хэсгийн ахлагч (Ж.Ганболд)-д үүрэг болгосугай.

3. Аяны хүрээнд харьяа айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг бүрэн оролцуулах нэгдсэн төлөвлөгөөг гарган зохион байгуулж, үр дүн тооцон явцыг олон нийтэд мэдээлж, тайланг удирдамжинд заасан хугацаанд аймгийн Эрүүл мэндийн газарт тайлагнахыг сумдын Засаг дарга нар, агентлаг, төрийн өмчит болон аж ахуй нэгж байгууллагуудын дарга, эздэд үүрэг болгосугай.

4. Аяныг зохион байгуулахад шаардлагатай зардлыг байгууллагууд болон хандивлагч байгууллагуудаас бүрдүүлж ажиллахыг байгууллагын дарга нарт зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Д.Батцуж
Ж.Ганболд

“ЭРҮҮЛ АХУЙН ГУРВАН ДАДАЛ” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Үндэслэл, шаардлага.

Хөвсгөл аймгийн Мөрөн сум нь хүн ам өсөхийн хэрээр агаар орчны бохирдол нэмэгдэж байгаа ба 2018 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллогоор Мөрөн сум нь энгийн айл өрхийн 9850 зуух, ААНБ, үйлчилгээний 459 зуух, 3-10 кВт хүчин чадалтай 220, 10-100 кВт хүчин чадалтай 3 зуух, үйлдвэрийн технологийн 6 зуух, дулааны станц 1 тоологдсон байна. Эдгээр зуухнууд нь жилдээ 34100 тн нүүрс түлж байна. Агаарын бохирдлын өнөөгийн байдлаар агаарт агуулагдах тоосны хэмжээ стандартаас 1 дахин давж байгаа ба хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг нь жилийн дунджаар стандарт даваагүй боловч сар, хоногийн дунджаар стандарт хэмжээнээс давж бохирдох тохиолдол их байна. Энэ байдалд арга хэмжээ авахгүй бол орчны бохирдол эргээд эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөөтэй, өрхийн санхүү, эрүүл мэндийн салбарт дарамт бий болж байна. Тухайлбал, дэлхийн хэмжээнд 8 нас баралтын 1 нь агаарын бохирдлоос, Улаанбаатарт 10 нас баралтын 1 нь агаарын бохирдолтой холбоотой байна. Мөрөн сумын хэмжээнд гарч буй амьсгалын замын өвчлөл аймгийн нийт өвчлөлийн 50 орчим хувийг эзэлж байна. Судалгаагаар агаарт агуулагдах тоос, хүхэрлэг хий, азотын давхар ислийн хэмжээний өсөлт амьсгалын замын өвчлөлийн өсөлттэй шууд хамааралтай байгаа нь тогтоогджээ. Мөн агаарын бохирдолд хамгийн их өртдөг бүлэг бол 0-5 насны хүүхэд байна.

Мөрөн сум 2008 онд жилд 21 тонн хог хаягдал гаргадаг байсан бол 2016 онд 40 тонн болж 1 дахин нэмэгдсэн байна. Байгаль хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, эдийн засаг нийгмийн асуудлууд бүгд хоорондоо салшгүй уялдаа холбоотойгоор оршин тогтнодог. Иймээс нэгийг нь дагнан хэрэгжүүлнэ гэдэг нь үр дүнгүй байдаг. Энэ нөхцөл байдлаараа явбал цаашид үүсэх том асуудал бол хөрс, ус, агаарын бохирдлын асуудал, үүнээс үүдэх өвчлөл юм. Гэтэл хогоо гудамжинд ил задгай асгадаг, жорлонгоо дүүргэхгүйн тулд бохир усаа ил задгай асгадаг байдал нийтлэг байна.

Өрхийн хөгжил -Хүүхэд хамгаалал өрхийн судалгаагаар 36,5% нь орчны эрүүл мэнд, эрүүл ахуйн нөхцөл өндөр эрсдэлтэй байна. Иймд Мөрөн сумаас гадна хөдөө орон нутгийн сумд ч мөн адил асуудал нэмэгдсээр байна. Иймд ирээдүйн эздийг хүмүүжүүлж байгаа залуу гэр бүл, ирээдүйг өөрчлөх эрч хүчээ зөв зүйлд зориулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү аяныг зохион байгуулж байна.

Хоёр: Зорилго:

Хувь хүн, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад гар угаах, ариун цэврийн байгууламжаа сайжруулах, хогоо хогийн саванд хийх талаар мэдлэг дадлыг бий болгох идэвхжүүлэх замаар хөдөлгөөн өрнүүлж айл өрх албан байгууллагуудын ус ариун цэврийн нөхцөлийг сайжруулахд чиглэнэ

Гурав: Зорилт:

1. Аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн газрын даргын А/14, А/25 дугаар тушаалын дагуу нийт хүн амын 30%-ийг сургалтанд хамруулах
2. Гар угаах орчин нөхцөлөө сайжруулсан айл өрх, ААНБ-уудын тоог нэмэгдүүлэх
3. Стандарт бие засах газартай болсон айл өрх, ААНБ-уудын тоог нэмдүүлэх
4. Ялган ангилдаг хогийн савтай болсон айл өрх, ААНБ-уудын тоог нэмэгдүүлэх

Дөрөв: Хамрах хүрээ:

Хөвсгөл аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, үйлчилгээний газрууд, тэдгээрийн ажилтан, албан хаагчид, айлөрх, иргэд хамрагдана.

Тав: Хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 01-аас 10 дугаар сарын 15 хүртэл

Зургаа: Тайлан авах хугацаа: 2019 оны 10 дугаар сарын 15-20ны хооронд

Долоо: Хэрэгжүүлэгч байгууллага: Аймгийн ЗДТГ, ЭМГазар, БОАЖГазар, Мөрөн сумын ЗДТГазар, Дэлгэрмөрөн, Шишхэд голын СГЗ, Хөвсгөл нуур-Эгийн голын сав газрын захиргаа, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын газар, Боловсрол соёл урлагын газар, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтнууд, Дэлхийн зөн ОУБ-ын Хөвсгөл аймаг дахь салбар

Найм: Хүрэх үр дүн, үр нөлөө. Сууришлын улмаас тохиолддог хамгийн том асуудал болох орчны бохирдол, түүнээс үүдэх өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд ААНБ-ууд, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэн байна.

Ес: АЙЛ ӨРХИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

1. Өрхийн гишүүдийн 50-иас доошгүй хувь нь сургалтанд хамрагдсан байна
2. Ус хадгалах зориулалтын тэмдэглэгээтэй савтай болох
3. Гар угаах орчин нөхцөлийг бүрдүүлсэн /гишүүд бүр тусдаа гарын алчууртай, гарын савантай, гар угаах ус хангалттай хэмжээтэй/ байх
4. Хог хаягдлыг ил задгай асгахгүй байх /2 бошигин хогийн савтай, шар ногоон өнгөөр ялган будсан байна, тагтай, бариултай байна/
5. Хог хаягдлыг эх үүсвэр дээрээ ялгаж хэвшсэн байх
6. Стандарт бие засах газартай болсон байна /MNS5924:2015/

Арав. ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

1. Байгууллагын ажилчдыг 100% сургалтанд хамруулсан байх
2. Төлөвлөгөө гарган иргэдэд, ААНБ-уудын 70-аас доошгүй хувьд сургалт, сурталчилгаа зохион байгуулсан байх
3. Гар угаах орчин нөхцөл бүрдүүлсэн байх /цаасан алчуур, гарын шингэн саван, гар ариутгагчтай/
4. Ялган ангилдаг хогийн савыг байгууллагын гадна дотор талд байршуулах, тэмдэгжүүлэх
5. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ялган ангилж хэвшсэн байх
6. Байгууллагын хог хаягдлыг хадгалах түр цэгийг Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна
7. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй нүхэн жорлонг ариутгал хийх, дүүрсэн тохиолдолд ариутгал халдваргүйтгэл хийлгэн дарж булаах
8. Бохирын төвлөрсөн шугаманд холбогдох боломжгүй бол нүхэн жорлонг MNS 5924: 2015 стандарт шаардлага хангасан байхаар шинээр барьж байгуулан нээлттэй болгох

Арван нэг. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ БОЛОН СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

1. Байгууллагын нийт ажилчдыг 100% сургалтанд хамруулах
2. Хүүхдүүдэд гар угаах, зөв бие засах дадлыг бий болгох сургалт зохион байгуулах
3. Эцэг эхчүүдийн 70-аас доошгүй хувийг ус ариун цэврийн сургалтанд хамруулах
4. Гар угаах орчин нөхцөл бүрдүүлсэн байх /гар хатаагчтай, гарын шингэн савантай/
5. Ялган ангилдаг хогийн савыг байгууллагын гадна дотор талд байршуулах, тэмдэгжүүлэх
6. Байгууллагын хог хаягдлыг хадгалах түр цэгийг Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна
7. Мөрөн сумын хот тохижилт үйлчилгээний газартай гэрээ байгуулан, хог хаягдлыг гудамж талбайд ил задгай хаяхгүй түр хадгалах байрнаас тээвэрлүүлж хэвшсэн байх
8. Ашиглагдахгүй байгаа шаардлага хангахгүй нүхэн жорлонг ариутгал хийж дарж булаах
9. Бохирын төвлөрсөн шугаманд холбогдох боломжгүй бол нүхэн жорлонг MNS 5924: 2015 стандарт шаардлага хангасан байхаар шинээр барьж байгуулан нээлттэй болгох

Арван хоёр: АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ

1. Аж ахуйн нэгж байгууллагын нийт ажилчдын 50-аас доошгүй хувь нь сургалтанд хамрагдах
2. Гар угаах орчин нөхцөл бүрдүүлсэн байх /гар хатаагчтай, гарын шингэн савантай/
3. Ялган ангилдаг хогийн савыг байгууллагын гадна дотор талд байршуулах, тэмдэгжүүлэх
4. Байгууллагын хог хаягдлыг хадгалах түр цэгийг Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна
5. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй аж ахуйн нэгж байгууллагууд нүхэн жорлонг ариутгал хийх, дүүрсэн тохиолдолд ариутгал халдваргүйтгэл хийлгэн дарж булах
6. Бохирын төвлөрсөн шугаманд холбогдох боломжгүй ААНБ-ууд нь олон нийтэд үйлчлэх нүхэн жорлонг MNS 5924: 2015 стандарт шаардлага хангасан байхаар шинээр барьж байгуулан нээлттэй болгох
7. Ариун цэврийн байгууламжийг үйлчлүүлэгчдэд нээлттэй байлгах, тэмдэг тэмдэглэгээ байршуулах

Арван нэг: Дүгнэх урамшуулах

- А. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ 5 урамшуулах
- Б. Эрүүл мэндийн байгууллага бүр дээрх шаардлагыг хангасан өрхүүдийг шалгаруулж сурталчилан НЭМ-ийн зардлаас 5-аас доошгүй айл өрхийг /нийт 140 айл өрх/ шагнаж урамшуулах

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 10-ны өдрийн
А/193 дугаар захирамжийн 2 дугаар
хавсралт

**“ЭРҮҮЛ АХУЙН 3 ДАДАЛ АЯН”-НЫ ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Ганболд –Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Ж.Лхагвасүрэн –Эрүүл мэндийн газрын НЭМТ-ийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Д.Батцоож –Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

С.Бямбасүрэн- Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн

Б.Хандармаа – БОАЖГ-ын мэргэжилтэн

З.Соёлмаа- Мөрөн сумын ЗДТГ-ын БОХУБайцаагч

Ч.Одбаяр –Мэргэжлийн хяналтын газрын эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч

М.Даваадулам- Гэр бүл, хүүхдийн хамгааллын үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

С.Мөнх-Эрдэнэ - Боловсрол соёл урлагийн газрын мэргэжилтэн

Б.Галиндэв – Хөвсгөл нуур-Эгийн гол СГЗ мэргэжилтэн

Х.Санчирдулам –Дэлгэрмөрөн, шишхэд ГСЗ мэргэжилтэн

Ч.Уранчимэг -Далайн элбэрэлт өрхийн эрүүл мэндийн НЭМА

Ө.Баттогтох - Дэлгэрмөрөн өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМА

Ж.Мөнхцэцэг - Гурван гал өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМА

Д.Оюунцэцэг – “Энэрэл” өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМА

“Энх-Үйлс” өрхийн эрүүл мэндийн төвийн НЭМА



**МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A1194

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11 дэх заалт, Шадар сайд, Газар хөдлөлтөөс урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/08 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох харилцаа холбооны орон нутагт мөрдөх журмыг боловсруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.


2. Гамшгийн албад тус бүр болзошгүй гамшиг нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед салбар хоорондын мэдээлэл солилцох журманд оруулах саналаа заасан хугацаанд ирүүлэхийг албадын дарга нарт үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагааг нэгтгэн төлөвлөж, салбар хоорондын уялдаа холбоог ханган, журмыг боловсруулан аймгийн гамшгийн эрсдлийг бууруулах салбар зөвлөлд тайлагнахыг Эрүүл мэндийн газрын дарга (М.Үүрийнбаяр)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэг бологосугай.

ДАРГА  Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Д.Батцуж
Ж.Ганболд

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: М. Үүрийнбаяр-Эрүүл мэндийн газрын дарга

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

Д.Өлзийсайхан-ЭМГ-ын Тархвар судлал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: н. Ундармаа- Мэдээлэл харилцаа холбооны газар

О.Очирхуяг-“Хөвсгөл- Эрчим хүч “ХХК-ийн дарга

Г.Адьяасүрэн-Цаг уур орчны шинжигээний газрын дарга

Ц.Адьяацэрэн-Цагдаагийн газрын дарга

Б.Ганхуяг- Мал эмнэлэгийн газрын дарга

Г.Баттулга-Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Эрдэнэхуяг-Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын дарга

Б.Ганзориг-Газрын харилцаа хот байгуулалтын газрын дарга

Ө.Баттулга-Авто тээврийн газрын дарга

Ё.Пүрэвсүрэн-Онцгой байдлын газрын дарга

А.Эрдэнэбаатар-Мэргэжилийн хяналтын газрын дарга

Э. Батболд-Улаан загалмайн хорооны дарга

С.Чагнаадорж-Нэгдсэн эмнэлэгийн дарга

Б.Уртнасан-Зооноз өвчин судлалын төвийн дарга

н.Лхагважаргал-Түмний ТВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/195

Мөрөн сум

Иргэдэд газар өмчлүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай" хуулийн 7.1, 12.1.3, 21.1, 21.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2.5, 94 дүгээр зүйлийн 94.1, Мөрөн сумын ИТХ-ын 2018 оны IX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэний өргөдөл, Мөрөн сумын Засаг даргын өргөн мэдүүлснийг харгалзан нэр бүхий 4 иргэний газар эзэмших эрхийг цуцалж, 1916м² газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар хавсралт ёсоор баталж өмчлүүлсүгэй.

2. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газраа өмчилж авахаар шийдвэр гаргуулсан иргэдийн газрыг улсын бүртгэлд бүртгэж, баталгаажуулахыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

3. Хувийн хэргийн бүрдүүлэлтийг ханган, өмчилсөн газрыг улсын бүртгэлд бүртгэж, мэдээллийн санд оруулж захирганы актыг оролцогчиддоо мэдэгдэхийг аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.


4. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

5. Газар өмчлөгчийн үүргийн биелэлтэнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Аймгийн мэргэжлийн хяналтын газар (Д.Лхагвасүрэн), Мөрөн сумын засаг дарга (Ц.Гансүх) нарт тус тус даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Б.Эрдэнэдалай
Б.Эрдэнэдалай

Аймгийн Засаг даргын 2019 оны 05 дүгээр сарын 10-ны өдрийн
А/19 дугаар захирамжийн хавсралт

Д/Д	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистрийн дугаар	Зориулалт	Газрын байршил /хаяг/	Газрын хэмжээ /м2/	Газрын үнэ /мян.төг/	Нэгж талбарын дугаар	Хүчингүй болох		
										Огноо дугаар	Хавсралтын дугаар	
1	Гөрөөчин	Түмэн	Мөнх-Очир	РЮ78012475	Гэр, орон сууцны хашааны газар	05-р баг, - 32, 4	772	2316.0	6712000491	2009.08.04 А/110	5 дугаар заалт	
2	Боржгон	Дэлгээ	Баярхүү	МТ74050116	Гэр, орон сууцны хашааны газар	09-р баг, - 4, 7	622	1866.0	6712012452	2017.04.28 А/81	Тухайн захирамж бүхэлдээ	
	Хонин онход	Алтанзул	Алтансүх	РЮ91122111	Гэр, орон сууцны хашааны газар	01-р баг, - 42, 8	511	1533.0	6712013976	2016.12.16 А/180	1 дүгээр заалт	
4	Хаирад	Пүрэв-Ойдов	Мөнхбат	РУ74110412	Гэр, орон сууцны хашааны газар	14-р баг, - 27, 11	11	33.0	6712014494	2019.03.07 А/48	2 дугаар заалт	
							1916					

_____ ооо



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A197

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр дүгээр зүйлийн 29.1.5.а, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 44 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Дархад хурд-6”, Дэлгэрхаан уулын их тахилга, Цагаан адууны баяр, хурдан морины уралдааныг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Х.Ган-Очир- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүдэд:

Г.Гандэлгэр- аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Э.Аззаяа- аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Г.Сувд- аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Г.Энхбаяр- аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт- шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Л.Батбаяр- аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга

Ц.Нармандах- аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Ү.Тэмүүжин – Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан

Ц.Адъяацэрэн- Аймгийн Цагдаагийн газрын дарга

Р.Жаргалсайхан- Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга

Л.Батцэцэг- Аймгийн Хөгжимт драмын театрын даргын үүргийг хавсран гүйцэтгэгч

Ч.Дашбаяр-Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга

В.Нэргүй- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга

Ж.Төмөрсүх- Хөвсгөлийн улаан тайгын улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргааны дарга

И.Балжинням – Дархад зон нийгэмлэгийн тэргүүн

Б.Гансүх - Дархан зон нийгэмлэгийн гишүүн

Б.Ганхуяг-Мал эмнэлгийн газрын дарга

Ю.Батдэлгэр- Ренчинлхүмбэ сумын уугуул Улаанбаатар хотод амьдардаг Асоббшим ХХК-ны захирал

Б.Баярсайхан- Биеийн тамир спортын газрын дарга

2.

О.Баянмөнх- Ренчинлхүмбэ сумын Улаанбаатар хот дахь, нутгийн зөвлөлийн дарга

И.Батцогт -Улаан-Уул сумын Улаанбаатар хот дахь, нутгийн зөвлөлийн дарга

П.Доржпалам -Баянзүрх сумын Улаанбаатар хот дахь, нутгийн зөвлөлийн дарга

Д.Лхагва-Эрдэнэ –Цагааннуур сумын Улаанбаатар хот дахь, нутгийн зөвлөлийн дарга

М.Рагчаа- Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн

Э.Мягмаржав- Хөдөө аж ахуйн их сургуулийн багш

Батжаргал- Монгол Улсын их сургуулийн багш

Г.Эрдэнэбилэг- Авто тээврийн үндэсний төвийн мэргэжилтэн

Г.Батцогт- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч


З.Элбэгзаяа –“Синчи ойл” ХХК-ийн захирал

Г.Элбэг- Монгол улсын Харцага

Нарийн бичгийн дарга: О.Бадраа –“Эрдмийн далай” цогцолбор сургуулийн захирал

2. Уралдааны бэлтгэл зохион байгуулалтыг хангаж, ёслол хүндэтгэлийн өндөр хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Х.Ган-Очир), захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ц.Баттогтох) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь

Б. Болормаа
Б. Болормаа
Б. Болормаа
Б. Болормаа



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/198

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.6-гийн "г", Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.3, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаал 2.1.6 дахь заалт тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Мөрөн сумын ахмад зураач Д.Цэвэгдоржийн уран бүтээлийн ажилд 2,000,000 төгрөг, "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн идэрчүүдийн хангайн бүсийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох сурагчдын унааны зардалд 730,000 төгрөг, Хөвсгөл аймгийн "Хүүхдийн шатрын холбоо"-ны үйл ажиллагаанд 2,500,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх 5,230,000 (Таван сая хоёр зуун гучин мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Г.Нарангэрэл
Г.Нарангэрэл



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 10 өдөр

Дугаар А/199

Мөрөн сум

Тусламж, дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-гийн "г", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 9 дүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Амьдралын аргагүй байдлыг харгалзан Мөрөн сумын иргэн Д.Лхамсүрэнд 100,000, Т.Эрдэнэчулуунд 73,400 төгрөг, Шинэ-Идэр сумын иргэн Ч.Лодойжамц 100,000 төгрөг, Тосонцэнгэл сумын иргэн Ч.Байнаа 50,000 төгрөгийг эмчилгээний зардалд, үзэж Д.Уртнасанд 100,000 төгрөг, Д.Тэрбишд 50,000 төгрөг, Б.Атарцэцэгт 50,000 төгрөг, Ц.Баатарт 50,000 төгрөг, Б.Бямбасүрэнд 50,000, Рэнчинлхүмбэ сумын иргэн Л.Нарантуяад 50,000 төгрөгийн тусламж, "Авъяас" сургуулийн сурагч Х.Ууганбаярын ОХУ-ын Киргизистанд зохион байгуулагдах цээж бодолтын аварга шалгаруулах тэмцээнд оролцох замын зардалд 100,000 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.
2. Дээрх 773400 (Долоон зуун далан гурван мянга дөрвөн зуун) төгрөгийг Засаг дарга данснаас гаргаж зарцуулахыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогч (Ч.Мөнхтуяа) -д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Х.Ган-Очир)-д үүрэгболгосугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД

Боловсруулсан:
Хянасан:
2 хувь



Г.Нарангэрэл
Г.Нарангэрэл